



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

Бор-Өндөр

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/59

Ой, хээрийн түймрийн голомтод ажиллах
шуурхай бүлэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь хэсэг, Улсын Онцгой комиссын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн "Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" №01 албан даалгавар, Засгийн газрын 339, 340 дүгээр тогтоол, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.16 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт хээрийн түймэр гарсан үед голомтод ажиллах 1, 2, 3 дугаар шуурхай бүлэг болон автомашины томилгоог 1 дүгээр хавсралтаар, хээрийн түймэрт гарах 1, 2, 3 дугаар ээлжийн шуурхай бүлгийн багаж, хэрэгслийн томилгоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хээрийн голомтод ажиллах шуурхай бүлгүүдийг шаардлагатай техник, багаж хэрэгслээр хангаж ажиллахыг Засаг даргын орлогч, мэргэжлийн ангийн дарга (Х.Галбадрах)-д, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах, аврах 49 дүгээр ангийн захирагч (ахмад О.Тэгшжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ГАДЪЯАБИЛЭГТ